



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/71/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Мөнгөншагай Утас: 90909190 Цахим хаяг: Mungunshagai.J@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Агуулга

1.Аудитын дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол улсын засгийн газар



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ӨЛЗИЙТ СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН ДАРГА У.ҮҮРЦАЙХ ТАНАА

2022.02.28 № 90
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Өлзийт сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд 111,799,428.0 төгрөгийн халаалтын өр төлбөртэй ажиллажээ. Батлагдсан орон тооноос нэг орон тоогоор илүү ажиллуулан 2,532,490 төгрөгийн цалин олгосон зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлүүдийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.4 дахь заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,713,000.00	24,977,000.00
2	БАРАА МАТЕРИАЛ	22,713,000.00	24,977,000.00
3	Хангамжийн материал	22,713,000.00	24,977,000.00
4	Аж ахуйн материал	22,713,000.00	24,977,000.00
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,464,007,280.71	1,447,676,714.91
6	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,464,007,280.71	1,447,676,714.91
7	Биет хөрөнгө	1,462,377,280.71	1,446,046,714.91
8	Барилга, байгууламж, орон сууц	1,466,610,398.22	1,471,110,398.22
9	Хуримтлагдсан элэгдэл	-37,358,331.96	-67,541,760.96
10	Машин тоног төхөөрөмж(компьютер)	22,370,035.00	37,223,685.00
11	Хуримтлагдсан элэгдэл	-13,902,270.25	-15,719,336.65
12	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,271,303.20	39,271,303.20
13	Хуримтлагдсан элэгдэл	-25,640,993.50	-28,719,313.90
14	Бусад үндсэн хөрөнгө	7,760,100.00	7,760,100.00
15	Хуримтлагдсан элэгдэл	-5,135,100.00	-5,885,100.00
16	Ном	8,402,140.00	8,546,740.00
17	Биет бус хөрөнгө	1,630,000.00	1,630,000.00
18	Бусад биет бус хөрөнгө	1,630,000.00	1,630,000.00
19	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,486,720,280.71	1,472,653,714.91
20	НИЙТ ӨР ТӨЛБӨР	76,652,205.00	111,799,428.00
21	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	76,652,205.00	111,799,428.00
22	Өглөг	76,652,205.00	111,799,428.00
23	Бусад өглөг	76,652,205.00	111,799,428.00
24	Байгууллагад төлөх өглөг	76,652,205.00	111,799,428.00
25	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,410,068,075.71	1,360,854,286.91
26	Засгийн газрын хувь оролцоо	1,410,068,075.71	1,360,854,286.91
27	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	42,521,641.50	42,521,641.50
28	Хуримтлагдсан үр дүн	1,226,187,409.33	1,176,973,620.53
29	Өмнөх үеийн үр дүн	1,289,736,905.45	1,226,187,409.33
30	Тайлант үеийн үр дүн	-63,549,496.12	-49,213,788.80
31	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	141,359,024.88	141,359,024.88
32	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,486,720,280.71	1,472,653,714.91

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	133,528,420.00	147,931,550.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,544,020.00	12,591,150.00
3	Нийтлэг татварын бус орлого	6,544,020.00	12,591,150.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,544,020.00	0.00
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,544,020.00	0.00
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	12,591,150.00
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	126,984,400.00	135,340,400.00
8	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	5,947,200.00

9	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	5,947,200.00
10	Орон нутгийн төсвөөс санхүүжих	126,984,400.00	129,393,200.00
11	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	126,984,400.00	129,393,200.00
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	197,077,916.12	197,145,338.80
13	УРСГАЛ ЗАРДАЛ	197,077,916.12	197,145,338.80
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	196,777,916.12	196,706,538.80
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	78,031,900.00	80,031,300.00
16	Үндсэн цалин	78,031,900.00	80,031,300.00
17	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,533,600.00	10,804,200.00
18	Тэтгэврийн даатгал	7,218,225.83	7,603,000.00
19	Тэтгэмжийн даатгал	780,300.00	800,200.00
20	ҮОМШӨ-ний даатгал	624,300.00	640,300.00
21	Ажилгүйдлийн даатгал	350,274.17	160,100.00
22	Эрүүл мэндийн даатгал	1,560,500.00	1,600,600.00
23	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,847,221.00	68,323,323.00
24	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	940,100.00
25	Түлш, халаалт	67,247,221.00	67,247,223.00
26	Цэвэр, бохир ус	100,000.00	136,000.00
27	Байрны түрээс	0.00	0.00
28	Хангамж, бараа материалын зардал	703,900.00	635,400.00
29	Бичиг хэрэг	139,000.00	86,500.00
30	Тээвэр, шатахуун	229,300.00	318,100.00
31	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	30,000.00
32	Ном, хэвлэл	66,300.00	17,500.00
33	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	199,300.00	183,300.00
34	Нормативт зардал	49,000.00	0.00
35	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	0.00
36	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	15,000.00
37	Урсгал засвар	100,000.00	15,000.00
38	Томилолт, зочны зардал	70,500.00	70,500.00
39	Дотоод албан томилолт	70,500.00	70,500.00
40	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,648,000.00	998,000.00
41	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500.00	772,500.00
42	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00
43	Газрын төлбөр	145,500.00	145,500.00
44	Бараа үйлчилгээний бусад зардал	34,793,795.12	35,828,815.80
45	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,793,795.12	35,828,815.80
46	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	438,800.00
47	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	438,800.00

48	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	438,800.00
49	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-63,549,496.12	-49,213,788.80
50	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-63,549,496.12	-49,213,788.80

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	42,521,641.50	141,359,024.88	1,226,187,409.33	1,410,068,075.71
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	42,521,641.50	141,359,024.88	1,226,187,409.33	1,410,068,075.71
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-49,213,788.80	-49,213,788.80
4	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	42,521,641.50	141,359,024.88	1,176,973,620.53	1,360,854,286.91

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	126,984,400.00	135,340,400.00
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	126,984,400.00	135,340,400.00
3	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	5,947,200.00
4	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	5,947,200.00
5	Орон нутгийн төсвөөс санхүүжих	126,984,400.00	129,393,200.00
6	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	126,984,400.00	129,393,200.00
7	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	126,984,400.00	128,433,300.00
8	УРСГАЛ ЗАРДАЛ	126,984,400.00	128,433,300.00
9	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	126,684,400.00	127,994,500.00
10	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	78,031,300.00	80,031,300.00
11	Үндсэн цалин	78,031,300.00	80,031,300.00
12	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,534,200.00	10,804,200.00
13	Тэтгэврийн даатгал	7,218,825.83	7,603,000.00
14	Тэтгэмжийн даатгал	780,300.00	800,200.00
15	ҮОМШӨ-ний даатгал	624,300.00	627,300.62
16	Ажилгүйдлийн даатгал	350,274.17	173,099.38
17	Эрүүл мэндийн даатгал	1,560,500.00	1,600,600.00
18	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,700,000.00	33,740,100.00
19	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	1,540,100.00
20	Түлш, халаалт	32,100,000.00	32,100,000.00
21	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00
22	Хангамж, бараа материалын зардал	551,400.00	551,400.00
23	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00
24	Тээвэр, шатахуун	229,300.00	229,300.00

25	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	70,000.00
26	Ном, хэвлэл	66,300.00	66,300.00
27	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.00	119,300.00
28	Нормативт зардал	49,000.00	49,000.00
29	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	49,000.00
30	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00
31	Урсгал засвар	100,000.00	100,000.00
32	Томилолт, зочны зардал	70,500.00	70,500.00
33	Дотоод албан томилолт	70,500.00	70,500.00
34	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,648,000.00	2,648,000.00
35	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500.00	2,422,500.00
36	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00
37	Газрын төлбөр	145,500.00	145,500.00
38	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	438,800.00
39	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	438,800.00
40	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	438,800.00
41	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	6,907,100.00
42	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	6,907,100.00
43	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	6,907,100.00
44	Дотоод эх үүсвэрээр	0.00	6,907,100.00
45	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	6,907,100.00
46	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-6,907,100.00
47	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
48	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
49	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	129,393,200.00	129,393,200.00	0.00	100.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	129,393,200.00	129,393,200.00	0.00	100.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	128,954,400.00	128,954,400.00	0.00	100.00
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	80,031,300.00	80,031,300.00	0.00	100.00
5	Үндсэн цалин	80,031,300.00	80,031,300.00	0.00	100.00
6	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,804,200.00	10,804,200.00	0.00	100.00
7	Тэтгэврийн даатгал	7,603,000.00	7,603,000.00	0.00	100.00
8	Тэтгэмжийн даатгал	800,200.00	800,200.00	0.00	100.00
9	ҮОМШӨ-ний даатгал	640,300.00	627,300.62	12,999.38	97.97
10	Ажилгүйдлийн даатгал	160,100.00	173,099.38	-12,999.38	108.12
11	Эрүүл мэндийн даатгал	1,600,600.00	1,600,600.00	0.00	100.00

12	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,700,000.00	34,700,000.00	0.00	100.00
13	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,500,000.00	0.00	100.00
14	Түлш, халаалт	32,100,000.00	32,100,000.00	0.00	100.00
15	Цэвэр, бохир ус	100,000.00	100,000.00	0.00	100.00
16	Хангамж, бараа материалын зардал	551,400.00	551,400.00	0.00	100.00
17	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00	0.00	100.00
18	Тээвэр, шатахуун	229,300.00	229,300.00	0.00	100.00
19	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	70,000.00	0.00	100.00
20	Ном, хэвлэл	66,300.00	66,300.00	0.00	100.00
21	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.00	119,300.00	0.00	100.00
22	Нормативт зардал	49,000.00	49,000.00	0.00	100.00
23	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	49,000.00	0.00	100.00
24	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00	0.00	100.00
25	Урсгал засвар	100,000.00	100,000.00	0.00	100.00
26	Томилолт, зочны зардал	70,500.00	70,500.00	0.00	100.00
27	Дотоод албан томилолт	70,500.00	70,500.00	0.00	100.00
28	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,648,000.00	2,648,000.00	0.00	100.00
29	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500.00	2,422,500.00	0.00	100.00
30	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00	0.00	100.00
31	Газрын төлбөр	145,500.00	145,500.00	0.00	100.00
32	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	438,800.00	438,800.00	0.00	100.00
33	Бусад урсгал шилжүүлэг	438,800.00	438,800.00	0.00	100.00
34	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	438,800.00	438,800.00	0.00	100.00
35	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	129,393,200.00	129,393,200.00	0.00	100.00
36	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	129,393,200.00	129,393,200.00	0.00	100.00
37	Орон нутгийн төсвөөс	129,393,200.00	129,393,200.00	0.00	100.00
38	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.00
39	Төсвийн байгууллага	1	1	0	100.00
40	АЖИЛЛАГСАДЫН ТОО	8	9	1	100.00
41	Удирдах ажилтан	1	1	0	100.00
42	Гүйцэтгэх ажилтан	4	5	1	100.00
43	Үйлчлэх ажилтан	3	3	0	100.00
44	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	8	9	1	100.00
45	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	5	6	1	100.00
46	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3	0	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,947,200.00

2	УРСГАЛ ЗАРДАЛ	5,947,200.00
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,947,200.00
4	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,947,200.00
5	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,947,200.00
6	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,947,200.00
7	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,947,200.00
8	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,947,200.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлзийт сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлзийт сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21 -ны өдрийн 2 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлзийт сумын Соёлын төв нь ард иргэдэд соёл урлаг, олон нийтийн арга хэмжээг зөв боловсон хүргэж, хүүхэд залуучуудын авъяас билгийг нээн илрүүлж, олныг хүртээл болгох мөн соёлын үйлчилгээний цар хүрээг өргөтгөж соёлын стандартын шаардлагыг хангах зорилготой соёл урлагын үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн төсвөөс санхүүждэг, төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Соёл урлагийн хүртээмжтэй олон талт үйлчилгээг нийгэмд хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий, тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай орон нутгийн онцлог шинжийг харуулсан соёл урлагийн үйлчилгээг хүргэх” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Соёлын тухай хуулийг 2021 оны 7 дугаар сарын 02-ний өдөр шинэчлэн найруулсан байна. Харин санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”

- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагаа зохион байгуулаагүй байна.

Өлзийт сумын Соёлын төв нь Архангай аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/841 дүгээр тушаалаар батлагдсан Соёлын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд бусад эрх бүхий байгууллагаас болон хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй тул дотоод хяналт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлзийт сумын Соёлын төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 129.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 1.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 14.1 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	22.7	24.9	2.2	9.7
Үндсэн хөрөнгө	1,464.0	1,447.7	(16.3)	-1.1
Нийт хөрөнгө	1,486.7	1,472.6	(14.1)	-0.9
Богино хугацаат өр төлбөр	76.7	111.8	(30.4)	-39.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,410.1	1,360.9	(49.2)	-3.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,486.7	1,472.6	(14.1)	-0.9

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 9.7 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 22.7 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 2.9 сая төгрөг нэмэгдэж, тайлант онд 0.6 сая төгрөгийн зарцуулалт гарч, 24.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 16.3 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,464.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба төсвийн хөрөнгөөр 6.9 сая, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 12.6 сая төгрөгийн нийт 19.5 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн бол тайлант хугацаанд байгуулсан 35.8 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 1,447.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 49.2 сая төгрөгөөр буурсантай холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	127.0	129.4	2.4
Нэмэлт санхүүжилтийн орлого		5.9	5.9
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	6.5	12.6	6.1
Үйл ажиллагааны орлого	133.5	147.9	14.4
Цалин, шимтгэлийн зардал	88.5	90.8	2.3
Бусад бараа үйлчилгээний зардал	108.3	105.9	(2.4)
Урсгал шилжүүлэг	0.3	0.4	0.1
Үйл ажиллагааны зардал	197.1	197.1	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(63.6)	(49.2)	14.4

Өлзийт сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 6.1 сая төгрөгөөр өссөн нь БСШУЯамнаас олгосон 7.9 сая төгрөгийн техник хэрэгсэл, сумын ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн 4.5 сая төгрөгийн хайстай холбоотой байгаа бол нэмэлт санхүүжилтийн орлого 5.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн ЗДТГазраас олгосон тоног төхөөрөмжийн үнэтэй тус тус холбоотой байна

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 213.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 84.3 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 129.4 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 129.4 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 129.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн ЗДТГазраас тоног төхөөрөмж худалдан авах зардалд 5.9 сая төгрөгийн санхүүжилт ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус Соёлын төв нь 2021 онд шинээр батлагдсан Ковид-19 цар тахлын үед улс, аймаг сумын онцгой комиссоос аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгааны дагуу соёл урлагийн үйлчилгээг хориглосны улмаас соёл урлагийн болон олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Мөн тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Соёлын тухай хуулийг 2021 оны 7 дугаар сарын 02-ний өдөр шинэчлэн найруулан батлаж 2022 оноос дагаж мөрдөж байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 129.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 10 хувь буюу 0.4 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэл байхгүй тул судалгааг гаргаж ирүүлээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өлзийт сумын Соёлын төв нь 2021 онд 142 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 109 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 33 мэдээллийг хугацаа хоцроож, 55.2 сая төгрөгийн 7 мэдээллийг байршуулаагүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаарлага өгөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Тухайн тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 10 % буюу 0.4 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 175.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 35.8 сая төгрөгийн алдааг залруулж, 2.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 137.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 4 алдаа, зөрчлийн дүн 140.0 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 1.0 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд 35.8 сая төгрөгийн элэгдлийн зардлыг тооцоогүй алдаа илэрсэнд аудитын явцад залрууллаа.

4.2 Албан шаардлага

Цалин орон тоог тулган шалгахад нэг орон тоо илүү ажиллуулан 2.5 сая төгрөгийн цалин олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т заасны дагуу батлагдсан орон тоондоо багтаан ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

4.3 Зөвлөмж

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

Тайлант онд түлш халаалтын 111.8 сая төгрөгийн өр төлбөртэй ажилласан байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтын дагуу өр төлбөр үүсгэхгүй ажиллах, өр төлбөрийг барагдуулан ажиллах

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Тус байгууллагын 2021 оны үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалтын дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийх, хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үнэлж, үр дүнг тооцож ажиллах

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 35 нэр төрлийн 25.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тухайн хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж одоо ашиглаж байгаа болон цаашид ашиглагдах хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "НББ-ийн дансны заавар"-ын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, харин ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг ТБОНӨТХуулийн 31 дэхь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
					Загруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
1	Өлзийт сумын СТөв	Тайлант онд түлш халаалтын 111.8 сая төгрөгийн өр төлбөртэй ажилласан	1	111.8							1	111.8
2		Тус байгууллагын 2021 оны үйл ажиллагаа болон санхүү, төсвийн гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийгдээгүй	1								1	
3		Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 35 нэр төрлийн 25.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй	1	25.7							1	25.7
4		Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцоогүй 35.8 сая төгрөгийн алдаа илэрсэн	1	35.8	1	35.8						
5		Нэг орон тоо илүү ажиллуулан 2.5 сая төгрөгийн цалин олгосон	1	2.5					1	2.5		
Дүн			5	175.8	1	35.8			1	2.5	3	137.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Өлзийт сумын СТөв	МУЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилт 10 % буюу 0.4 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна	1	0.4					1	0.4		
2		33 мэдээлэл хугацаа хоцроосон, 55.2 сая төгрөгийн 7 мэдээллийг байршуулаагүй	1	55.2					1	55.2		
Дүн			2	55.6					3	58.1		
Нийт дүн			7	231.4	1	35.8			3	58.1	3	137.5